



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/29 дүгээр тушаалтын 4 дүгээр хавсралтыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд Коронавируст халдварт /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдвартгүйжүүлэлт хийх ажлыг халдвартын тархалтын түвшинтэй уялдуулан зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлын үед нийслэлд халдвартгүйжүүлэлт хийх зохион байгуулалтын чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Коронавируст халдварт /Ковид-19/-ын үед Нийслэлд зохион байгуулж буй урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдвартгүйжүүлэлтийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханганд зөвлөгөө өгч ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал /Н.Цогбадрах/-д үүрэг болгосугай.
3. Коронавируст халдварт /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдвартгүйжүүлэлтэд гарч буй зардлын судалгааг гарган шаардлагатай санхүүжилтийн асуудлыг тухай бүр Улсын онцгой комисст тавьж шийдвэрлүүлж байхыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгаланд даалгасугай.
4. Энэхүү тушаалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуянд даалгасугай.

ДАРГА С.АМАРСАЙХАН  
vKA0168

Улсын онцгой комиссын даргын  
2021 оны 29 сарын 20-өдрийн  
тушаалын нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн ахлагч:

Зоонозын өвчин судлалын үндэсний  
төвийн ерөнхий захирал Н.Цогбадрах

Гишүүд:

Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн Б.Жаргал

МХЕГ-ын эрүүл ахуйн халдварт хамгааллын  
улсын ахлах байцаагч Д.Батдулам

Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн тандалт судалгааны албаны  
дарга Ж.Байгалмаа

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн  
Халдварт судлагч эмч М.Цолмон

Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд  
захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр

Нийслэлийн эрүүл мэндийн газрын  
мэргэжилтэн Х.Мандухай

Нарийн бичгийн дарга:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн  
дэд захирал Б.Амгаланбаяр

Улсын онцгой комиссын даргын  
2021 оны 29. сарын 24.дэх  
туслаалын хоёрдугаар хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД НИЙСЛЭЛД  
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ**

№	Нөхцөл байдал	Халдвартүүлэлтийн төрөл	Халдвартүүлэлт хийх хариуцах нэгж	Баримтлах эрх зүй	Удирдлага зохион байгуулалт мэргэжил арга зүйгээр хангах
1.	Худалдаа, үйлчилгээний болон хүн амд олноор үйлчлэх аж ахуйн нэгжүүд	- Урьдчилан сэргийлэх халдвартүүлэлт - Цэвэрлэгээ	- Тухайн байгууллага аж ахуйн нэгж - Гэрээтэй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж		
2.	Орон сууц, нийтийн байр	- Урьдчилан сэргийлэх халдвартүүлэлт - Цэвэрлэгээ	- Тухайн байгууллага аж ахуйн нэгж - Сууц өмчлөгчдийн холбоо		
3.	Хоёрдугаар хавьтлын маршрут, ажлын байр, гэр	- Энгийн цэвэрлэгээ, халдвартүүлэлт	- Хувь хүн		- Эрүүл мэндийн яам - Нийслэлийн эрүүл мэндийн газар
4.	Нэгдүгээр хавьтлын маршрут, ажлын байр, гэр	- Энгийн цэвэрлэгээ, халдвартүүлэлт	- Тухайн байгууллага аж ахуйн нэгж - Гэрээтэй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж	- 2021 оны эрүүл мэндийн сайдын A/29 дүгээр туслаал - ЭМЯ, ЗЭСҮТ-өөс гаргасан зөвлөмж	- Зоонозын өвчин судлалын үндэсний төв - Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв
5.	Батлагдсан тохиолдлын гэр, ажлын байр	- Урьдчилан сэргийлэх - Голомтын эцсийн халдвартүүлэлт	- Харьяа дүүргийн эмнэлэг - Өрхийн ЭМТ - НОК болон НЗАА-тай гэрээ байгуулж, зөвшөөрөл авсан тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж - Иргэн	- 2020 оны ЗЭСҮТ-ийн A/15 дугаар туслаал	
6.	Батлагдсан тохиолдлын сүүлийн 24 цагт явсан маршрут	- Урьдчилан сэргийлэх халдвартүүлэлт - Цэвэрлэгээ	- Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж - Тухайн байгууллага, аж ахуйн нэгж		
7.	Батлагдсан болон эрсдэлт бүлгийн хүн амыг зайлшгүй шаардлагаар тусгаарласан тусагаарлан ажиглах байр	- Урьдчилан сэргийлэх - Цэвэрлэгээ - Голомтын эцсийн халдвартүүлэлт	- Тусгаарлах байрны ажилчид - Аж ахуйн нэгж өөрсдөө - ЗЭСҮТ		
8.	Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага	- Урьдчилан сэргийлэх - Цэвэрлэгээ - Голомтын эцсийн халдвартүүлэлт	- Тухайн эрүүл мэндийн байгууллагын баг		Тухайн үйл ажиллагаа бүрт Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хяналт тавьж, алдаа дутагдал зөрчлийг арилгуулна.